

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 8
1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай/	4 - 8
2. Үндэсний аудитын газрын тайлан /хаалттай/	

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 37 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар,
Д.Өнөрболор, С.Ганбаатар, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний Аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн шинэ төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас гар өргөж санал хураалт явуулья гэсэн горимын саналыг гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Г.Тэмүүлэн: “Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Байнгын хорооны тогтоол батлагдсантай холбогдуулан Үндэсний аудитын газарт чиглэл өгөв.

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Үндэсний аудитын газрын тайлан /хаалттай/

Хэлэлцэх асуудлын дараалалд орсон Үндэсний аудитын газрын тайланг хаалттай горимоор хэлэлцэв.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 14 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
10 цаг 37 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Хавдисламын	Баделхан	гишүүн,
Жигжидийн	Батжаргал	гишүүн,
Хүрэлбаатарын	Булгантуяа	гишүүн,
Цэрэнпилийн	Даваасүрэн	гишүүн,
Салдангийн	Одонтуяа	гишүүн,
Бөхчулууны	Пүрэвдорж	гишүүн,
Цэндийн	Сандаг-Очир	гишүүн,
Дуламдоржийн	Тогтохсүрэн	гишүүн,

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай/

Нэгдүгээр асуудал. “Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав дарга танилцуулна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя.

Чимэдийн Хүрэлбаатар гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх хоёр асуудал байна.

Нэгдүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл. Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай.

Хоёр. Аудитын газрын тайлан хэлэлцэх. Татан буугдсан банктай холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилт үр нөлөө. Хаалттай гэсэн ийм хоёр асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав дарга танилцуулна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ядамын Самбууням Үндэсний Аудитын газрын Аудитын нэгдсэн

удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор.

3 номерын микрофоныг өгье. Д.Загджав дарга. Ажлын хэсгийн 3 номер.

Д.Загджав: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өглөөний мэнд дэвшүүлье.

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага өнөөгийн байдлаар 496 орон тоотойгоор 7 мянга гаруй байгууллага, санхүүгийн тайлангийн аудит, давхардсан тоогоор 12 мянга орчим байгууллагыг хамруулан гүйцэтгэл-нийцлийн аудит аудитыг хийж байна.

Манай улсын эдийн засаг өсөж байгаагийн хэрээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа өргөжин тэлж, нийгэмд чухал нөлөөтэй томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж, улсын төсвийн нийт орлого, зардал өсөн нэмэгдэж байгаатай уялдан төсвийн сахилга, санхүү, үйлчлэлийн үр дүн, үр өгөөжид төрийн хяналтын чиг үүргийг сайжруулах шаардлага улам бүр ихсэж, төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитын тоо, ажлын цар хүрээ өргөжиж, аудитын ажлын ачаалал нэмэгдэж байгаа юм.

Тодорхой жишээ дурдвал сүүлийн 3 жилийн дунджаас харахад нэг төсөв захирагчийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд 2.2 хүн өдөр зарцуулахын зэрэгцээ 200 гаруй гүйцэтгэл-нийцлийн аудитыг гүйцэтгэж, нэг аудитор 4.7 аудитыг гүйцэтгэж, аудитад зарцуулах дундаж хугацаа 80 орчим хуанлигийн хоног байгаа нь гүйцэтгэлийн аудитыг 90-ээс 180 хоногт

гүйцэтгэдэг олон улсын жишгээс 2.6 дахин богино байгаа ба аудитын үр дүн, илрүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсээд байгаа юм.

Өөрөөр хэлбэл хүний нөөц дутмаг байгаагаас шалтгаалан зарим санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын хуулийн этгээдээр гүйцэтгэл-нийцлийн аудитад мэргэшсэн инженер, нарийн мэргэжлийн шинжээч нарыг гэрээгээр ажиллуулах зайлшгүй шаардлага байнга тулгарч байгаа юм.

Иймд Төсвийн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолыг баталсан орон тоог 99 аудитаар нэмэгдүүлж, дээд хязгаарыг 585 болгох тооцоо судалгааг хийн танилцуулж байгаа бөгөөд уг асуудал шийдэгдсээр хуульд заасны дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл сайжирч, аудитын илрүүлэлт нэмэгдэх бодит цагийн аудитыг хийж гүйцэтгэх шат шатны төсөв захирагч нарын хариуцлагыг дээшлүүлэх зэрэг олон үр дүн гарах болно.

Эрхэм гишүүд Та бүхнийг дээрх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Нэг, хоёр зүйлийг тодруулж асууя.

Өнгөрсөн долоо хоногт аудитын байгууллага албан бичгээр орон тоогоо нэмэгдүүлэх, орон тооныхоо дээд хязгаарыг шинэчлэн батлуулах энэ асуудлыг оруулж ирсэн.

Ингээд дахиад энэ асуудлыг гаргаж ирж байна.

Ерөнхийдөө хүн хүч дутмаг байгаа гэдэг үүднээс оруулж ирж байна.

Яг Байнгын хорооны гишүүдэд та мэдээлэл өгөөдхөөч. 90 орчим хүний орон тоо нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Санхүү-нийцэл болоод гүйцэтгэлийн аудитаар хүн хүч дутмаг байгаа. Аудитын үйл ажиллагааг цаашид саадгүй явуулах үүднээс орон тоо зайлшгүй шаардлагатай байна гэдэг асуудлыг ярьж байгаа.

Энэ 90 орчим хүнээр нэмэгдүүлэх асуудал маань энэ жил нэмэгдүүлэх асуудал биш биз дээ?

Тэгээд яг хэдий хугацаанд, ямар хугацаанд, эсвэл таны танилцуулга дээр та сая уншсанаар 3 жилийн хугацаанд шат дараалалтайгаар төсөвтөө багтаан нэмэгдүүлэх саналтай байна гэсэн үг ирж байна.

Тэгэхээр 2025 он, 2026 он, 2027 оны гэсэн байдлаар нэмэгдүүлэх ийм төлөвлөгөө гэж ойлгож болох уу? Тийм ээ. Нэг талдаа гишүүд санаа зовж байгаа зүйл маань төсөв батлагдчихсан учраас энэ жил ямар нэг байдлаар орон тоо нэмэгдүүлэх, төсвийн дундуур зардал нэмэгдүүлэх асуудал болох вий.

Угаасаа боломжгүй асуудал байгаа гэдэг зүйлийг яриад байгаа юм.

Энэ дээр дэлгэрэнгүй та нэг товч мэдээлэл тайлбар өгөөдхөөч. Д.Загджав дарга. 3 номер ажлын хэсэг.

Д.Загджав: Г.Тэмүүжин даргын асуултад хариулъя.

Тэгэхээр бид бүхэн улс орны эдийн засаг тэлэхийн хэрээр манай ажлын объект нэмэгдээд, тэгээд хараат бусаар төрийн аудитын байгууллага бүх төсөв санхүүд гүйцэтгэл-нийцлийн аудит хийхэд хүн хүч дутмаг.

Аймгуудад арван хэдэн орон тоотойгоор төсөвт захирагч нарын ажлыг шалгадаг аудитор маань өөрөө тэр арван хэдэн хүнийхээ нягтлан бодох бүртгэлийг хөтлөөд сууж байх жишээтэй гээд ер нь төвдөө ч хүртэл орон тоо нэлээн дутуу ийм байгаа юм.

Тэгээд манай хувьд 40 гаруй тэрбум төгрөгийн төсөвтэй байдаг.

Энэ 2025 оноос эхлэх юм. Тэгээд 2025 оны төсөв дээр 6, 7 тэрбум төгрөг л нэмэгдэнэ. Илүү юм байхгүй. Энэ ондоо бол биш.

Тэгэхээр тавин хэдэн тэрбум төгрөг л болох юм. Манай төсөв.

Г.Тэмүүлэн: Та яг ирэх онуудад яаж яаж төлөвлөгөөгөө 90 орчим хүнээр нэмэхээр. Одоо яг хаана хаана хуваарилах вэ?

Орон нутаг дээр нэмэгдүүлэх юм уу, ажлынхаа ачааллаас хамаараад ямар ямар юм нь дээр. Тэр дээр нэг тайлбар өг дөө. Д.Загджав дарга.

Д.Загджав: Г.Тэмүүжин даргын асуултад хариулъя.

Бид наадах 99 хүнийг ирэх оноос нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа.

Зүгээр орон нутаг дээрээ гурав, гурван хүн нэмэхгүй бол үнэхээр болохгүй байгаа юм.

Тэгээд 21 аймаг, нийслэл гээд ингээд нэмэхээр нийслэлдээ арай түлхүү. Тэгээд төвдөө ч бас дутмаг байгаа.

Ингээд үлдэх хэсэг нь төв дээрээ нэмэгдээд явах юм.

Аймгууд чинь тухайлбал туслах үйлчилгээний ажилтан гэж манайд ч байдаггүй, аймаг орон нутагт ч байдаггүй юм шүү дээ.

Жолооч ч байдаггүй. Аймгууд.

Г.Тэмүүлэн: Би дахиад нэмж саналаа хэлэх гээд байгаа юм. Д.Загджав дарга аа. Үүнийг анхаараадхаарай.

Яг энэ орон тооны нэмэгдэл хэрэв та хэд. Юу ч гэсэн эхлээд санал хурааа даа.

Тэгээд гишүүд дараа нь тодорхой нэг санал хэлье гэж бодоод байна.

Тэгье. Х.Баделхан дарга. Эхлээд тест санал хураалт. Дэлгэц дээрээ дарах юм байна. Эхний тест санал хураалт явуулаадагъя. Гишүүд шинэ төхөөрөмж байгаа учраас туршиж үзээрэй. Санал хураалт. Тестийнх.

Эхлээд хурууныхаа хээг хийх юм байна. Гараа авлаа. Зөвшөөрсөн гэдгээ дарах юм байна.

Зөвшөөрөх. Дахиад тест үзээдэхье. Ч.Хүрэлбаатар сайдынх ажиллахгүй байна. Дахиад нэг туршилтын тест. Туршилтын санал хураалт.

Хуруугаа хийх юм байна. Авлаа. Зөвшөөрсөн гэж гарч ирж байна. Татгалзсан гэж хоёр санал хувилбартай байна.

Ж.Батжаргал дарга болохгүй байна. Горимын санал гаргачих уу?

Дахиад нэг тест туршилтынхаа хийгээд үзээдэхье. Туршилтын санал хураалт. /алх цохив/

Би горимын санал гаргачихъя даа. Тэгээд төхөөрөмж яг бүрэн дүүрэн. Шинэ төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас гараараа санал хураалт явуулъя гэсэн горимын саналыг гаргаж байна.

Тэгээд горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Гараараа.

Гишүүд гараар илээр санал хураалт явуулахыг дэмжиж байна уу?

10-аас 6 дэмжлээ. 60.0 хувиар дэмжигдлээ.

Ингээд горимын санал дэмжигдсэн учраас Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

10-аас 6 гишүүн дэмжлээ. 60.0 хувиар дэмжигдлээ.

Тогтоол батлагдаж байгаатай холбогдуулж би Д.Загджав даргад чиглэл өгч байгаа юм.

Энэ орон тооны бид зүгээр дээд хязгаарыг нь л баталж байгаа шүү.

Тэгэхээр би тэмдэглэлд оруулж байгаа зүйл бол яг ажилд нэмэр болох, дэмжих үйл ажиллагааны орон тоог нэмэгдүүлэхэд Та бүхэн анхаарах ёстой.

Аудиторууд дээр яг ачааллыг нь харж байж хуваарилах ёстой шүү. Орон тооны нэмэгдлээ зайлшгүй ажлын ачаалал болон яг аудитыг чиг үүргийнхээ албан хаагчаа нэмэгдүүлж авч чадавхжуулахад та хэд нэгдүгээрт анхаарах ёстой.

Хоёрдугаарт, голлоод энэ орон нутаг руугаа нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаарай. Орон нутаг дээр ажлын ачааллууд онцгой их байгаа. 10-аас 13 хүнтэй байдаг дундаж үзүүлэлтүүд гарсан байсан.

Тэгэхээр аймгуудынхаа хүн амын тоо, төсвийнхөө гүйцэтгэл, өөрөө төсвөө бүрдүүлдэг эсэх, тэгээд нөгөө стратегийн орд газар гэсэн үзүүлэлтүүдээр нь харгалзаж үзэж энэ орон тооны нэмэгдлийг анхаарч үзэх ёстой. Албан

хаагчдынхаа тоог бодитоор тогтоох ёстой.

Ингээд энэ нэмэгдлүүд 2025, 2026, 2027 он гэсэн энэ 3 жилийн хугацаанд 90 орчим хүнээр нэмэгдэх энэ дээд хязгаарыг Төсвийн байнгын хорооноос тогтоож өгч байгаа.

Тэгээд энэ дээр төлөвлөгөөгөө гаргаад, нарийвчлаад, эргээд гүйцэтгэл, төлөвлөгөө юмнуудаа буцааж танилцуулаарай гэдэг чиглэлийг Та бүхэнд өгч байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хоёрдугаар асуудалдаа орцгооё.

Хоёр.Үндэсний аудитын газрын тайлан

/хаалттай/

Хуралдаан 14 минут үргэлжилж, 11 цаг 34 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД